



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ
ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн тэмдэглэгээ хэрэглэх журам/

2008 оны 11-р сарын 28-ний өдөр
Улаанбаатар хот

Дугаар 756

Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 261.7, 271.1.1 дэх заалт, Улсын гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн тэмдэглэгээ хэрэглэх журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.
2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга бөгөөд Хяналт, эрсдлийн удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.
3. Энэ тушаалыг 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА Д.ЦЭВЭЭНЖАВ

Улсын бүртгэлд 2008 оны
12 дугаар сарын 01-ний өдрийн 2968 дугаарт
бүртгэсэн